



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/001-НА-СТА-ТШЗ

| | | |
|---|--|--|
| Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn | Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Аудитор: Утас: 7036-3047 | Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn Ж.Цогт Цахим хаяг: Tsogtj@audit.gov.mn |
| Сүхбаатар сум 2025 он | | |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

| | |
|---|-------|
| 1. Аудитын дүгнэлт | 2-4 |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл | 5-9 |
| 3. Санхүүгийн тайлангийн тодруулга | 10-14 |
| 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа | 10 |
| 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин | 10 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 11 |
| 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт | 11-12 |
| 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв | 12-14 |
| 4. Аудитын тайлан | 14-25 |
| 4.1 Ерөнхий зүйл | 14 |
| 4.2 Материаллаг байдал | 14-15 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт | 15 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 15 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 15-16 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 16 |
| 5. Аудитын илрүүлэлт | 16-20 |
| 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл | 21-22 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---------|--|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ГХУСАХЗ | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчийн Хурал |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий аудитор |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| УИХ | Улсын Их Хурал |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Э.ОЮУНБОЛД ТАНАА

2025.02.25 № ДАА-2025/001-НН-ДТН-ТЧУС
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан төрийн захиргааны 5 албан хаагчид олгосон 42,435.3 мянган төгрөгийн мөнгөн урамшууллаас хувь хүний орлогын албан татварын **4,243.5** мянган төгрөгийг суутгаагүй,
- Аймгийн Засаг даргын өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд тусгаагдаагүй атал төлөөлөгчид санал гаргаж, хэлэлцэн, баталсан гэх үндэслэлээр ИТХ-д суудалтай 2 намд нэг суудлыг 5,000 мянган төгрөгөөр тооцон нийт **185,000.0** мянган төгрөгийг зориулалт бусаар төлөвлөж, **180,000** мянган төгрөгийн санхүүжилт олгосон,

- Хурлын төлөөлөгчдийн хоол, зочид буудлын зардлыг хурлын ирцийг үндэслэн бодит гүйцэтгэлээр бус нийт гишүүдийн тоогоор тооцон **2,452.0** мянган төгрөгийг илүү зарцуулсан,
- Аймгийн ИТХ-ын хуралдааны үеэр ИТХ-ын “Ажлын алба”-ны албан хаагчид болон сэтгүүлчид гэх мэт давхардсан тоогоор 57 хүнд **5,741.1** мянган төгрөгийн хоолны зардлыг хуралдааны батлагдсан төсвөөс зориулалт бусаар зарцуулсан,
- Аймгийн ИТХ-аас бусдад олгох бэлэг дурсгалын зориулалт бүхий цаасан уутны 1,555.5 мянган төгрөгийн 183 ширхэг ашиглагдаагүй үлдэгдэлтэй атал нэмж **1,950.0** мянган төгрөгийг цаасан тор хийлгэхэд зарцуулж, ашиглалтгүй илүүдэл нөөц бүрдүүлсэн,
- Тус байгууллагын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан орон тооны төрийн жинхэнэ албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод заагдсан ажлыг давхардуулан гэрээгээр цахимаар гүйцэтгүүлж, цахим хаяг бүхий 2 хүнд **10,800.0** мянган төгрөг олгож, төсвийг үр ашиг, арвилан хэмнэлтгүй зарцуулсан,
- Жилийн эцэст буюу 12 дугаар сард төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлэлгүйгээр ИТХ-ын хуралдааны ил тод байдлыг хангах, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тодорхойлж, судалгаа хийлгэх гэх үндэслэлээр 2 аж ахуйн нэгжид **25,500.0** мянган төгрөгийг шилжүүлсэн боловч гэрээт ажлууд огт хийгдээгүй, санхүүгийн тайланд урьдчилж гарсан зардлаар бус шууд зардалд тайлагнасан,
- ИТХ-ын хуралдааны буюу ангилагдаагүй бусад зориулалт хөтөлбөрийн зардалд үндсэн үйл ажиллагааны хөтөлбөрийн хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлын батлагдсан төсвөөс 10,000.0 мянган төгрөг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, хөтөлбөрийн зардлаас 8,000.0 мянган төгрөг зэрэг нийт **18,000.0** мянган төгрөгийг хөтөлбөр хооронд гүйлгэн зориулалт бусаар зарцуулсан боловч гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй,
- Шууд худалдан авах босго үнээс давсан **26,000.0** мянган төгрөгийн тоног төхөөрөмжийн худалдан авах ажиллагааг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн байна.

Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.4, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6, Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.3.1, 22 дугаар зүйлийн 22.1, 22.1.1, Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.1.5, 34 дүгээр зүйлийн 34.6.3-д заасныг болон Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаал, 2024 оны А/03 дугаар тушаалаар баталсан журмын холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх “Нам дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, 10.1.5: “Энэ хуулийн 34.6-д заасан хориглосон этгээдээс санхүүжилт шууд болон шууд бусаар авах; 34.6.3: “Төрийн

байгууллага болон нутгийн өөрөө удирдах байгууллага” гэсэн заалтыг үндэслэн аймгийн ИТХ-д суудалтай намуудад нэг суудлыг 5,000 мянган төгрөгөөр тооцож, нийт 185,000.0 мянган төгрөгийг төлөвлөж, 180,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг 2 улс төрийн намд олгосон байна.

Аудитын гол асуудал

Аймгийн ИТХ-ын төсөвт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хөтөлбөрийн зардлыг тусган 482,000.0 мянган төгрөг баталснаас, аймгийн Цагдаагийн газар, ШШГГ, шүүх, прокурор зэрэг хууль, хяналтын байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд 481,574.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 2024 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г 7 зорилт, 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 96.0 хувийн биелэлттэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|---|---------------------|----------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 25,875,651.0 | 23,314,235.0 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 25,875,651.0 | 23,314,235.0 |
| 354 | Хангамжийн материал | 25,875,651.0 | 23,314,235.0 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 7,039,196.0 | 6,602,000.0 |
| 35420 | Аж ахуйн материал | 15,822,900.0 | 14,675,130.0 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,959,855.0 | 2,005,105.0 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 53,700.0 | 32,000.0 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 70,787,377.0 | 85,522,247.8 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 70,787,377.0 | 85,522,247.8 |
| 392 | Биет хөрөнгө | 70,787,377.0 | 85,522,247.8 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 126,800,000.0 | 126,800,000.0 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (124,924,999.8) | (126,800,000.0) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 104,284,900.0 | 128,959,700.0 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (52,693,208.8) | (76,179,479.5) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 23,848,300.0 | 43,459,200.0 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (6,527,614.4) | (10,717,172.7) |
| 39301 | Программ хангамж | 880,000.0 | 880,000.0 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (880,000.0) | (880,000.0) |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 96,663,028.0 | 108,836,482.8 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 96,663,028.0 | 96,663,028.0 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 96,663,028.0 | 96,663,028.0 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 99,213,204.0 | 99,213,204.0 |
| 51101 | Өмч: - төрийн | 99,213,204.0 | 99,213,204.0 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | (2,550,176.0) | (2,550,176.0) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (2,550,176.0) | (2,550,176.0) |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 96,663,028.0 | 96,663,028.0 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|------------------------|------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,467,792,360.5 | 1,673,258,162.6 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | - | 230,422.0 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | - | 230,422.0 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 230,422.0 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | - | 230,422.0 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,467,792,360.5 | 1,673,027,740.6 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 510,842,000.0 | 121,000,000.0 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 510,842,000.0 | 121,000,000.0 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 956,950,360.5 | 1,552,027,740.6 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 956,950,360.5 | 1,552,027,740.6 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,504,723,952.0 | 1,661,084,707.8 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,504,723,952.0 | 1,661,084,707.8 |

| | | | |
|-------------|---|-----------------------|---------------------|
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 821,639,608.0 | 1,275,722,068.8 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 292,131,155.6 | 380,899,666.0 |
| 210101 | Үндсэн цалин | 170,281,741.4 | 192,193,843.6 |
| 210102 | Нэмэгдэл | 79,074,346.7 | 146,554,665.3 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 9,489,068.5 | 19,750,000.0 |
| 210104 | Урамшуулал | 33,285,999.0 | 22,401,157.2 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 35,637,504.2 | 46,843,323.8 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,754,068.1 | 32,260,205.4 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,806,942.0 | 3,888,798.1 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,373,153.5 | 1,925,919.1 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 519,685.2 | 1,755,264.3 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,183,655.5 | 7,013,137.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 6,529,766.0 | 38,201,200.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,829,766.0 | 5,715,000.0 |
| 210302 | Түлш, халаалт | - | 27,371,500.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,700,000.0 | 5,114,700.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 71,396,799.5 | 100,713,989.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 31,620,968.0 | 49,676,346.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,863,026.0 | 17,770,172.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,306,545.0 | 1,602,436.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 19,606,260.5 | 31,665,035.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 9,450,600.0 | 20,000,000.0 |
| 210604 | Урсгал засвар | 9,450,600.0 | 20,000,000.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 18,328,400.0 | 17,541,000.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 18,328,400.0 | 17,541,000.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 290,663,211.9 | 600,350,320.8 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 287,727,747.9 | 597,773,656.8 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,260,525.0 | 1,260,525.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 958,939.0 | 206,139.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 25,000.0 | 22,000.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 691,000.0 | 1,088,000.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 97,502,170.8 | 71,172,569.2 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,822,777.5 | 737,400.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 53,213,341.5 | 40,884,340.0 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 27,466,051.8 | 29,550,829.2 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 683,084,344.0 | 385,362,639.0 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 185,000,000.0 | 180,000,000.0 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 185,000,000.0 | 180,000,000.0 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 498,084,344.0 | 205,362,639.0 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 494,000,000.0 | 142,213,360.0 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 42,435,259.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,084,344.0 | 20,714,020.0 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | (36,931,591.5) | 12,173,454.8 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 1,685,805.0 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 1,685,805.0 | - |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | (1,685,805.0) | - |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | (38,617,396.5) | 12,173,454.8 |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|------------------------|------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 1,467,792,360.5 | 1,673,027,740.6 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,467,792,360.5 | 1,673,027,740.6 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 510,842,000.0 | 121,000,000.0 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 510,842,000.0 | 121,000,000.0 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 956,950,360.5 | 1,552,027,740.6 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 956,950,360.5 | 1,552,027,740.6 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 1,457,634,160.5 | 1,637,326,740.6 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,457,634,160.5 | 1,637,326,740.6 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 774,549,816.5 | 1,251,964,101.6 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 293,872,084.6 | 380,899,666.0 |
| 210101 | Үндсэн цалин | 170,281,741.4 | 192,193,843.6 |
| 210102 | Нэмэгдэл | 80,815,275.7 | 146,554,665.3 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 9,489,068.5 | 19,750,000.0 |
| 210104 | Урамшуулал | 33,285,999.0 | 22,401,157.2 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 35,637,504.2 | 46,843,323.8 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,754,068.1 | 32,260,205.4 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,806,942.0 | 3,888,798.1 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,373,153.5 | 1,925,919.1 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 519,685.2 | 1,755,264.3 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,183,655.5 | 7,013,137.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 6,529,766.0 | 38,201,200.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,829,766.0 | 5,715,000.0 |
| 210302 | Түлш, халаалт | - | 27,371,500.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,700,000.0 | 5,114,700.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 51,976,765.5 | 57,001,473.8 |
| 210401 | Бичиг хэрэг | 14,603,500.0 | 18,694,050.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,500,000.0 | 11,000,000.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,486,545.0 | 1,602,436.0 |
| 210404 | Ном, хэвлэл | 675,000.0 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 16,711,720.5 | 25,704,987.8 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 9,578,600.0 | 28,844,930.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 8,365,030.0 |
| 210602 | Тавилга | - | 479,900.0 |
| 210604 | Урсгал засвар | 9,578,600.0 | 20,000,000.0 |
| 2107 | Томилот, зочны зардал | 18,328,400.0 | 17,541,000.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 18,328,400.0 | 17,541,000.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 287,985,427.2 | 636,297,020.8 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 285,049,963.2 | 633,720,356.8 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,260,525.0 | 1,260,525.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 958,939.0 | 206,139.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 25,000.0 | 22,000.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 691,000.0 | 1,088,000.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 70,641,269.0 | 46,335,487.3 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,896,177.5 | 966,147.3 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 53,745,091.5 | 45,369,340.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 683,084,344.0 | 385,362,639.0 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 185,000,000.0 | 180,000,000.0 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 185,000,000.0 | 180,000,000.0 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 498,084,344.0 | 205,362,639.0 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 494,000,000.0 | 142,213,360.0 |

| | | | |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 42,435,259.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,084,344.0 | 20,714,020.0 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 10,158,200.0 | 35,701,000.0 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 10,158,200.0 | 35,701,000.0 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 10,158,200.0 | 35,701,000.0 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 10,158,200.0 | 35,701,000.0 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 10,158,200.0 | 35,701,000.0 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (10,158,200.0) | (35,701,000.0) |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|--|---------------------------------|----------------------|--|
| C01 | 2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл | 99,213,204.0 | 24,621,683.8 | 123,834,887.8 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 99,213,204.0 | 3,706,249.3 | 102,919,453.3 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | (5,132,366.9) | (5,132,366.9) |
| C08 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 99,213,204.0 | (2,550,176.0) | 96,663,028.0 |
| D01 | 2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл | 99,213,204.0 | (2,550,176.0) | 96,663,028.0 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 99,213,204.0 | (2,550,176.0) | 96,663,028.0 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | 12,173,454.8 | 12,173,454.8 |
| D09 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 99,213,204.0 | 9,623,278.8 | 108,836,482.8 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|-----------------------|---|-----------------------|-----------------|---------------|-------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,710,968,000.0 | 1,552,027,740.6 | 158,940,259.4 | 90.7 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,710,968,000.0 | 1,552,027,740.6 | 158,940,259.4 | 90.7 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,434,148,000.0 | 1,287,665,101.6 | 146,482,898.4 | 89.8 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 446,358,900.0 | 380,899,666.0 | 65,459,234.0 | 85.3 |
| 210101 | Үндсэн цалин | 246,419,300.0 | 192,193,843.6 | 54,225,456.4 | 78.0 |
| 210102 | Нэмэгдэл | 151,243,700.0 | 146,554,665.3 | 4,689,034.7 | 96.9 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 15,840,000.0 | 19,750,000.0 | (3,910,000.0) | 124.7 |
| 210104 | Урамшуулал | 32,855,900.0 | 22,401,157.2 | 10,454,742.9 | 68.2 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 55,794,900.0 | 46,843,323.8 | 8,951,576.2 | 84.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 37,940,500.0 | 32,260,205.4 | 5,680,294.6 | 85.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,463,600.0 | 3,888,798.1 | 574,801.9 | 87.1 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,107,100.0 | 1,925,919.1 | (818,819.1) | 174.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,356,500.0 | 1,755,264.3 | 1,601,235.7 | 52.3 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,927,200.0 | 7,013,137.0 | 1,914,063.0 | 78.6 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 38,721,300.0 | 38,201,200.0 | 520,100.0 | 98.7 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,234,800.0 | 5,715,000.0 | 519,800.0 | 91.7 |
| 210302 | Түлш, халаалт | 27,371,500.0 | 27,371,500.0 | - | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,115,000.0 | 5,114,700.0 | 300.0 | 100.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 70,770,100.0 | 57,001,473.8 | 13,768,626.3 | 80.5 |
| 210401 | Бичиг хэрэг | 21,770,100.0 | 18,694,050.0 | 3,076,050.0 | 85.9 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,000,000.0 | 11,000,000.0 | - | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,000,000.0 | 1,602,436.0 | 1,397,564.0 | 53.4 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 35,000,000.0 | 25,704,987.8 | 9,295,012.3 | 73.4 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 66,000,000.0 | 64,545,930.0 | 1,454,070.0 | 97.8 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 26,000,000.0 | 24,935,030.0 | 1,064,970.0 | 95.9 |
| 210602 | Тавилга | 20,000,000.0 | 19,610,900.0 | 389,100.0 | 98.1 |
| 210604 | Урсгал засвар | 20,000,000.0 | 20,000,000.0 | - | 100.0 |

| | | | | | |
|-------------|---|-----------------|-----------------|----------------|-------|
| 2107 | Томиллт, зочны зардал | 18,500,000.0 | 17,541,000.0 | 959,000.0 | 94.8 |
| 210702 | Дотоод албан томиллт | 18,500,000.0 | 17,541,000.0 | 959,000.0 | 94.8 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 681,002,800.0 | 636,297,020.8 | 44,705,779.2 | 93.4 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 676,256,000.0 | 633,720,356.8 | 42,535,643.2 | 93.7 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 432,800.0 | - | 432,800.0 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,450,000.0 | 1,260,525.0 | 1,189,475.0 | 51.5 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 320,000.0 | 206,139.0 | 113,861.0 | 64.4 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000.0 | 22,000.0 | 22,000.0 | 50.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,500,000.0 | 1,088,000.0 | 412,000.0 | 72.5 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 57,000,000.0 | 46,335,487.3 | 10,664,512.8 | 81.3 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,000,000.0 | 966,147.3 | 9,033,852.8 | 9.7 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 47,000,000.0 | 45,369,340.0 | 1,630,660.0 | 96.5 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 276,820,000.0 | 264,362,639.0 | 12,457,361.0 | 95.5 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 185,000,000.0 | 180,000,000.0 | 5,000,000.0 | 97.3 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 185,000,000.0 | 180,000,000.0 | 5,000,000.0 | 97.3 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 91,820,000.0 | 84,362,639.0 | 7,457,361.0 | 91.9 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | - | 21,213,360.0 | (21,213,360.0) | - |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 25,100,000.0 | - | 25,100,000.0 | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 42,968,000.0 | 42,435,259.0 | 532,741.0 | 98.8 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 23,752,000.0 | 20,714,020.0 | 3,037,980.0 | 87.2 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,690,572,000.0 | 1,552,027,740.6 | 138,544,259.4 | 91.8 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 185,000,000.0 | - | 185,000,000.0 | - |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 185,000,000.0 | - | 185,000,000.0 | - |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,505,572,000.0 | 1,552,027,740.6 | (46,455,740.6) | 103.1 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 1,505,572,000.0 | 1,552,027,740.6 | (46,455,740.6) | 103.1 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 10.0 | 10.0 | - | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 2.0 | 2.0 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 5.0 | 5.0 | - | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 3.0 | 3.0 | - | 100.0 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|-------------|--|----------------------|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 121,000,000.0 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 121,000,000.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 121,000,000.0 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 121,000,000.0 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 121,000,000.0 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 121,000,000.0 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 121,000,000.0 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 121,000,000.0 |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал /цаашид аймгийн ИТХ гэх/ нь “Хуулиар олгогдсон бүрэн эрх, чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлдэг Сэлэнгэ нутгийн ард иргэдийн итгэлийг хүлээсэн хариуцлагатай төлөөллийн байгууллага байна” гэсэн эрхэм зорилгыг тавьж ажиллажээ.

Дэвшүүлсэн зорилгын хүрээнд дараах зорилт, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Хурлын стратеги төлөвлөгөө, жилийн ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих,
- Аймгийн ИТХ-ын болон зөвлөлийн хуралдааны бэлтгэлийг ханган, зохион байгуулж, хурлын байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах,
- Хууль, тогтоомж хурлын болон тэргүүлэгчдийн тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын гүйцэтгэлийн биелэлтэд хяналт тавих, үр дүнг тооцох, тайлагнах,
- Хурлын хороодын үйл ажиллагааг тогтмолжуулах, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх,
- Хурлын хамтын ажиллагааг өргөжүүлэх, гадаад улс, бусад аймаг, нийслэлийн ИТХ-тай хамтран ажиллах, иргэд олон нийттэй харилцах, хурлын шийдвэр, үйл ажиллагааг сурталчлах, мэдээлэл сонсгол зохион байгуулах, тайлагнах,
- Хуралдааны үйл ажиллагаанд орчин үеийн техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах,
- Хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг байгууллагын хэмжээнд зохион байгуулах, төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа хөтөлбөрийн хэрэгжилтийг байгууллагын хэмжээнд зохион байгуулж, тайлагнах,
- Хурлын хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулах гэх мэт.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Нийгмийн даатгалын ерөнхий хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 83 дугаар тогтоолоор төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмыг баталсан,

- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.*

Аймгийн ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас дотоод хяналт, аудит хэрэгжүүлдэг бөгөөд тайлант онд санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

Харин сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавьж ирсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн ИТХ-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/58 дугаар захирамжаар баталсан Сэлэнгэ аймгийн төсөвт байгууллагуудын хэмжээнд дагаж мөрдөгдөх *“Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”*-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн ИТХ-ын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан *“Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”*-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 12,173.5 мянган төгрөгөөр буюу 11.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|--|-------------------|--------------------|-----------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Бараа материал | 25,875.6 | 23,314.2 | (2,561.4) |
| Үндсэн хөрөнгө | 70,787.4 | 85,522.2 | 14,734.9 |
| Нийт хөрөнгө | 96,663.0 | 108,836.5 | 12,173.5 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 96,663.0 | 108,836.5 | 12,173.5 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 96,663.0 | 108,836.5 | 12,173.5 |

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Үүнд:

- Бараа материал дансны үлдэгдэл нь 23,314.2 мянган төгрөг болж, 2,561.4 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 122,358.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 124,920.0 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 85,522.2 мянган төгрөг болж, 14,734.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 24,674.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 19,610.9 мянган төгрөгийн тавилга худалдан авч, элэгдлийн зардал 29,550.8 мянган төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 2,651,429.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт 940,461.2 мянган төгрөгөөр бууруулж, 1,710,968.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн жилийн дундуур батлагдсан төсөвт зохицуулалт хийж, 1,710,968.0 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Үндсэн үйл ажиллагааны зардлыг 53,000.0 мянган төгрөгөөр бууруулан,
- Ангилалдаагүй бусад зориулалт арга хэмжээний зардлыг 53,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,710,968.0 мянган төгрөгийн төсөв баталж, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлээр 1,552,027.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна. Үүнд:

- Үндсэн үйл ажиллагааны зардалд 672,170.7 мянган төгрөг,
- Мэдээлэл, сурталчилгааны зардалд 15,000.0 мянган төгрөг,
- Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн зардалд 47,857.8 мянган төгрөг,
- Ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардалд 66,720.0 мянган төгрөг,
- Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн зардалд 25,100.0 мянган төгрөг,
- ИТХ-д суудалтай намуудад олгох санхүүжилтийн зардалд 185,000.0 мянган төгрөг,
- Ангилагдаагүй бусад зориулалт, арга хэмжээний зардалд 217,119.5 мянган төгрөг,
- ГХУСАХЗ-д 482,000.0 мянган төгрөг гэх мэт.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,552,027.7 мянган төгрөг буюу 90.7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 97,949.3 мянган төгрөгөөр, ангилагдаагүй бусад зориулалт, арга хэмжээний зардлыг 36,258.0 мянган төгрөгөөр, зөвлөл, хороо, комиссын гишүүдийн зардлын төсвийг 11,834.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|-----|--|--------------------|--------------------|------------------|-------------|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 672,170.7 | 574,221.4 | 97,949.3 | 85.4 |
| 2 | Мэдээлэл сурталчилгааны зардал | 15,000.0 | 14,985.0 | 15.0 | 99.9 |
| 3 | Зөвлөл, хороо, комиссын гишүүд | 47,857.8 | 36,022.9 | 11,834.9 | 75.3 |
| 4 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал | 66,720.0 | 63,149.3 | 3,570.7 | 94.6 |
| 5 | Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөний тэтгэмж | 25,100.0 | 21,213.4 | 3,886.6 | 84.5 |
| 6 | ИТХ-д суудалтай намуудад олгох санхүүжилт | 185,000.0 | 180,000.0 | 5,000.0 | 97.3 |
| 7 | Ангилагдаагүй бусад зориулалт, арга хэмжээ | 217,119.5 | 180,861.5 | 36,258.0 | 83.3 |
| 8 | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх | 482,000.0 | 481,574.3 | 425.7 | 99.9 |
| | Дүн | 1,710,968.0 | 1,552,027.8 | 158,940.2 | 90.7 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130050402 дугаар дансанд Цагаатгалын улсын комиссоос 121,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгогдсоныг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Шууд худалдан авах босго үнээс давсан компьютер, техник хэрэгсэл худалдан авах **26,000.0** мянган төгрөгийг худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүйгээр шууд худалдан авсан нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь “... нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно”, Засгийн газрын 2024 онд батлагдсан “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоолын хавсралтын 1 дэх: “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар - Бараа 20.0 сая төгрөг” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж байх албан шаардлага хүргүүлэв.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Цогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн ИТХ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,504,724.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу **15,047.2**

мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор аймгийн ИТХ нь бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг цахим хэлбэрт шилжүүлсэн, автомашиныг дотор албан хэрэгцээнд ашиглаагүй, зайлшгүй шаардлагатай зардлаас бусад зардлыг танасан зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлснээр дараах зардлуудыг хэмнэж, батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна. Үүнд:

- Цалин, нэмэгдэл урамшууллыг 65,459.2 мянган төгрөгөөр,
- Бичиг хэргийн зардлыг 3,076.0 мянган төгрөгөөр,
- Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардлыг 9,295.0 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 42,535.6 мянган төгрөгөөр гэх мэт.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан *“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”*-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд аймгийн ИТХ-ын мэдээлбэл зохих 159 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 02-ны 173 дугаар *“Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай”* албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 53,713.8 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 2 төлбөрийн акт тогтоон, 2 албан шаардлага /хариуцлага тооцуулах 1 албан шаардлага/ хүргүүлж, төсвийн төлөвлөлт, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 3 зөвлөмж өгснөөс 75.5 хувийг нь хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|--------------------------------------|------------------------|-----------------|----------|-----------------|-------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 1 | 415.4 | 1 | 415.4 | 100.0 |
| | 1 | 600.0 | 1 | 600.0 | 100.0 |
| Албан шаардлага | 1 | 22,091.6 | 1 | 20,141.6 | 80.0 |
| Хариуцлага тооцуулах албан шаардлага | 1 | 2 | 1 | 1 | 50.0 |
| Зөвлөмж | 1 | 18,012.4 | | | |
| | 1 | 6,525.5 | 1 | 6,525.5 | 100.0 |
| | 1 | 6,068.9 | 1 | 6,068.9 | 100.0 |
| Нийт дүн | 7 | 53,713.8 | 6 | 33,751.4 | 75.7 |

Өмнөх аудитаар өгөгдсөн хурлын төлөөлөгчдийн хоол, буудлын зардлыг хуралдааны ирцээр бус нийт гишүүдийн тоогоор шилжүүлсэн, шаардлагагүй материалын нөөц үүсгэсэн зэрэг зөрчлийг арилгах албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс тайлант онд зөрчлийг давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй,бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтыг үндэслэн аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Э.Оюунболд, Орон нутгийн өмч, төсөв, санхүүгийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Болормаа нарт **сахилгын шийтгэл ногдуулах** албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн үр дүнгийн тайлангийн тусламж, санхүүжилтийн орлогын эхний үлдэгдлийг өмнөх оны эцсийн үлдэгдлээс **6,534.7** мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн алдааг аудитын явцад залрууллаа.

Аудитаар нийт **255,071.6** мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 4,243.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 249,443.1 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 2 албан хаагчид хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэн, 1,385.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1 Төлбөрийн акт:

1. Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор батлагдсан *“Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”*-ын дагуу орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан төрийн захиргааны 5 албан хаагчид олгосон 42,435.3 мянган төгрөгийн мөнгөн урамшууллаас хувь хүний орлогын албан татвар **4,243.5** мянган төгрөгийг суутгаагүй байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь *“Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно”*, 6.3.1: *“цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого”*, 22 дугаар зүйлийн 22.1 дэх *“Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө”* 22.1.1: *“хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж”* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ХХОАТ-ыг нөхөн суутгаж, төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Албан шаардлага:

1. Өмнөх удаа, дараагийн аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс дараах зөрчлүүдийг давтан гаргасан байна. Үүнд:

1.1 Аймгийн Засаг даргын өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд тусгагдаагүй атал төлөөлөгчид санал гаргаж, хэлэлцэн, баталсан гэх үндэслэлээр ИТХ-д суудалтай 2 намд нэг суудлыг 5,000 мянган төгрөгөөр тооцон нийт **185,000.0** мянган төгрөгийг төлөвлөж, санхүүжилт олгосон байна. Энэ нь Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх *“Нам дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно”*, 10.1.5: *Энэ хуулийн 34.6-д заасан хориглосон этгээдээс санхүүжилт шууд болон шууд бусаар авах*; 34.6.3: *Төрийн байгууллага болон нутгийн өөрөө удирдах байгууллага”* гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Дараах зориулалт бус, хэрэгцээнээс илүү гарсан хоол, буудлын зардал гаргах, шаардлагагүй бараа материалын нөөц бүрдүүлэх зэргээр төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”*, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 дахь *“..... бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- Хурлын төлөөлөгчдийн хоол, зочид буудлын зардлыг хурлын ирцийг үндэслэн гүйцэтгэлээр бус нийт гишүүдийн тоогоор тооцон 2,452.0 мянган төгрөгийн, ИТХ-ын ажлын албаны бүх албан хаагчид болон сэтгүүлчдийг хуралдааны хоолны зардлын төсөвт тусган давхардсан тоогоор 57 хүнд

5,741.1 мянган төгрөгийн зэрэг нийт **8,193.1** мянган төгрөгийн илүү буюу зориулалт бус, арвилан хэмнэлтгүй зарцуулалт гаргасан.

- Аймгийн ИТХ-аас бусдад олгох бэлэг дурсгалын зориулалт бүхий цаасан уутны 1,555.5 мянган төгрөгийн 183 ширхэг ашиглагдаагүй үлдэгдэлтэй байхад **1,950.0** мянган төгрөгийг цаасан тор хийлгэхэд зарцуулж, ашиглалтгүй илүүдэл нөөц бүрдүүлсэн,
- Тус байгууллагад хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан орон тооны төрийн жинхэнэ албан хаагч ажилладаг атал социал орчинд зар мэдээ, ажлын тайлан тавих ажлыг гүйцэтгүүлэхээр иргэн Б.Амарзаяа /Сэлэнгэ түмэн цахим хуудас/, иргэн Т.Энхбаяр /Миний Монгол энтертайнмент/ нартай гэрээ байгуулан **10,800.0** мянган төгрөгийг олгон, төсвийг үр ашиг, арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу, үр ашиг, арвилан хэмнэлттэй зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

2. Жилийн эцэст буюу 12 дугаар сард төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлэлгүйгээр ИТХ-ын хуралдааны ил тод байдлыг хангах зорилгоор “Улаанбаатар телевиз ХХК”-тай байгуулсан гэрээний дагуу 6,000.0 мянган төгрөг, аймгийн хэмжээнд сүүлийн 5 жилийн хугацаанд бүртгэгдсэн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тодорхойлох судалгааны ажилд “Дижитал Оракл Монголиа ХХК”-тай байгуулсан гэрээний дагуу 19,500.0 мянган төгрөгийг тус тус шилжүүлсэн боловч гэрээт ажлуудыг хүлээн авалгүйгээр дээрх **25,500.0** мянган төгрөгийг урьдчилж гарсан зардлаар бус тайлант оны зардалд бүртгэж, тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 7 дугаар зүйлийн 7.7 дахь “... төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 дэх “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах,” Сангийн сайдын 2024 оны А/03 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 3.7 (г) дахь “Тайлант үед хамаарах бараа, ажил үйлчилгээний зардлыг дараах байдлаар бүртгэнэ: Дт: Урьдчилж төлсөн зардал /нэр төрлөөр/, Кт: Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр тооцоог урьдчилан хянаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах, гэрээт ажлыг хүлээн авах, нягтлан бодох бүртгэлийг үнэн зөв хөтөлж, тайлагнах албан шаардлага хүргүүлэв.

3. ИТХ-ын үндсэн үйл ажиллагааны хөтөлбөрийн хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлын батлагдсан төсвөөс ИТХ-ын хуралдааны буюу ангилагдаагүй бусад зориулалт хөтөлбөрийн бичиг хэргийн зардалд 1,750.0 мянган төгрөг, хоолны зардалд 2,568.4 мянган төгрөг, буудлын зардалд 2,300.0 мянган төгрөг, сургагч багшийн төлбөрт 3,381.6 мянган төгрөг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас төлөөлөгчдийг чадавхжуулах сургалтын зардалд 8,000.0 мянган төгрөг зэрэг нийт

18,000.0 мянган төгрөгийг хөтөлбөр хооронд гүйлгэн зориулалт бусаар зарцуулсан боловч гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалтууд буюу Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “*Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар*”-ыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үнэн зөв тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

4. Аймгийн ИТХ-ын холбогдох албан тушаалтнууд нь өмнөх удаа дараагийн аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, албан үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн, албан тушаалын эрх мэдлээ хэтрүүлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “*...хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно*” гэсэн заалтын дагуу аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Э.Оюунболд, орон нутгийн өмч, төсөв, санхүүгийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Болормаа нарт сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудал:

1.1 Илрүүлэлт: Тайлант онд худалдан авсан **1,385.0** мянган төгрөгийн албан бланк, бичиг хэргийн материалыг тухай бүр бус бөөн дүнгээр зарлагадсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “*Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг үндэслэн бараа материалын хөдлөл, өөрчлөлтийг тухай бүр бүртгэж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5² дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг

² Шалгадагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5² дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | | | |
|---|------------|----------------|-----------------------------------|-----|--------------------------|----------------|------------|-----|--------------|----------------|---------|-----|-----|-----|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Загруулсан | | Загруулаагүй | | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | | | | |
| Санхүүгийн үр дүнгийн тайлангийн эхний үлдэгдэл нь өмнөх оны эцсийн үлдэгдлээс зөрүүтэй | 1 | 6,534.7 | | | 1 | 6,534.7 | | | 1 | 6,534.7 | | | | |
| Дүн | 1 | 6,534.7 | | | 1 | 6,534.7 | | | 1 | 6,534.7 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|--|-------------|-----------|---------------|---------|-----------------|-----------|---------|-----|----------------------|-----|---|-----|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| Төрийн захиргааны 5 албан хаагчид олгосон мөнгөн урамшууллаас хувь хүний орлогын албан татвар суутгаагүй | 1 | 4,243.5 | 1 | 4,243.5 | | | | | | | | |
| Өмнөх албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр зөрчлийг давтан гаргасан | 1 | 205,943.1 | | | 1 | 205,943.1 | | | | | | |
| Гэрээт 2 ажлыг хүлээн авалгүйгээр урьдчилж гарсан зардлаар бус тайлант оны зардалд бүртгэж, тайлагнасан | 1 | 25,500.0 | | | 1 | 25,500.0 | | | | | | |

| | | | | | | | | |
|--|----------|------------------|----------|----------------|----------|------------------|----------|----------|
| Батлагдсан төсвийг хөтөлбөр хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй | 1 | 18,000.0 | 1 | 18,000.0 | | | | |
| Холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах | 1 | | | | | 1 | 2 | |
| Бараа материалыг бөөн дүнгээр зарлагадсан | 1 | 1,385.0 | | | 1 | 1,385.0 | | |
| Дүн | 6 | 255,071.6 | 1 | 4,243.5 | 3 | 249,443.1 | 1 | 2 |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|--|---------------|-----------------|-----------------|-----|----------|-----------------|
| | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | |
| Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй | 1 | 26,000.0 | | | 1 | 26,000.0 |
| Дүн | 1 | 26,000.0 | | | 1 | 26,000.0 |